

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИАС АЛБАН ХААГЧДАД
СУРГАЛТЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН ТУХАЙ**

2025 оны 09 дүгээр сарын 23

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер Осорын Оюунтуяа мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж, зохих шалгалт шүүлгийг амжилттай өгч, Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэшсэн мэргэжилтэн болсон. О.Оюунтуяад сургалтын явцад цалинтай чөлөө олгож, сурах нөхцөл бололцоогоор хангасан.

Компанийн Хөдөлмөрийн дотоод журам болон Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган жил бүр ажилтнуудыг чадавхжуулах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтанд хамруулах арга хэмжээг авч, Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6.2.5-д заасан цалинтай чөлөө өгөх хэлбэрээр дэмжлэг үзүүлж байна.


2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Хөдөлмөрийн хуульч С.Сэргэлэнгийн удирдлагаар зохион байгуулагдсан Хөдөлмөрийн хуулийн тухай сургалтад “Багахангай үйлдвэрлэл, технологийн парк” ХК, Паркийн нэгжүүдийн холбогдох албан хаагчид, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын газрын дарга, Нягтлан бодогч нар хамрагдав.

MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх сургалтад хамт олноороо хамрагдаж байна.

ХЯНАСАН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Б.БЯМБАЦЭЦЭГ

МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭСЭН.
ГАДААД ХАРИЛЦАА, ХҮНИЙ
НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН

 М.МӨНХДУЛАМ